



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АЙМАГ, СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
Ю.ДЭЛГЭРМААД

2024.08.01 № 251
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр
хуульд заасан шаардлагад
нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Ю.Дэлгэрмаагийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл,

2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Ю.Дэлгэрмаагийн аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Ю.Дэлгэрмаагийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (..... хуудас)-г хавсаргав.

Хувийг: Аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт ...6... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

Б.ДАРХАНБАТ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ШИВЭЭГОВЬ СУМ

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ Ю.ДЭЛГЭРМАА МӨРИЙН
ХӨТӨЛБӨР

2024.07.19


0000000001

**БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЮРА ОВОГТОЙ
ДЭЛГЭРМАА СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Шивээговь сумын сонгогчид оо

2024.07.19

Миний бие Юрагийн Дэлгэрмаа тус суманд ажиллаж амьдардаг. Жирийн нэгэн ээж, нэгэн айлын эзэгтэй байна. Би сумандаа ажиллаж амьдраад нэлээдгүй хугацаа өнгөрлөө. Энэ хугацаанд жижиг гэлтгүй сум минь нам там гэж талцан иргэнд биш намд үйлчлэх нь олон зүйл дээр харагдаж байна. Иймд би амьдарч байгаа сум орон нутгаа хөгжүүлэхийн төлөө сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд бие даан нэр дэвшихээр шийдвэрлэлээ. Цаашид орон нутгийн бизнес эрхлэгчид аж ахуйн нэгжүүдийг дэмжин ажиллах сумын иргэдийн эрх ашгийг хамгаалах зайлшгүй шаардлага тулгарч байна гэж үзэж байна.

Ийм жижиг сум орон нутагт талцан хуваагдахад цаашдын ажил амьдралд сөрөгөөр нөлөөлж бидний эрүүл аюулгүй амьдрах эрх зөрчигдөж, хийгдэх ёстой албан ажлууд удаашралтай байгаа нь нүдэнд ил байна.

Бидний залуучууд үүнийг зүгээр хараад суулгүйгээр эх орон сум орон нутгаа гэсэн сэтгэлтэй хүмүүсийн төлөөлөл болохоор шийдэж бие даан нэр дэвшиж байна. Болохгүй зүйлийн эсрэг зогсож болж байгаа зүйлийг сайшаан дэмжиж орон нутгаа өөдтэй өнгөтэй байлгахын төлөө үнэний дуу хоолой болж шудрага ёсны төлөөлөл болж ажиллана гэдгээ илэрхийлж байна.

Тиймээс иргэн та:

Эрх мэдэл, хөрөнгөтэй хэн нэгний захиалгаар нэр дэвшээгүй

Өөрийн үзэл бодол байр суурьтай

Үнэнч шударга зарчимч нэгнийг дэмжиж өөрт ээлтэй төрийг бүтээхэд гар бие оролцоорой.

Та бүхний итгэл найдварыг алдахгүй ажиллахын тулд дараах зүйлийг зорилт болгон дэвшүүлж байна.

- Сумын хэмжээний 10 барилга орон сууцнуудын 2 талд боржигон өв соёл, монгол түүх дурсгал агуулсан гэрэлтүүлэг хийнэ.
/ сум орон нутгийн өнгө үзэмж нэмэгдэнэ. /
- Сумын сургуулийн номын санг шинэчилж хүүхэд бүрт хүртээлтэй болгох мөн хичээлийн бусад цагаар хичээл хийх таатай орчин бүрдүүлэх ширээ сандал шинэчлэх
/ хүүхдүүд сурч байгаа орчиндоо тухтай орчинд хичээлээ хийх нөхцөл бүрдэнэ/
- Уул уурхайн салбар үйл ажиллагаа явуулж байгаа давуу талыг ашиглан ШОХК-тай хамтран аймгийн Политехникийн коллежид сумаас суралцаж байгаа хүүхдүүдийн дотуур байранд засвар хийж тохижуулах

0000000062

- / гэрээсээ хол сурч байгаа хүүхдүүдэд таатай орчин нөхцөл бүрдүүлэх, цаашлаад сургуулиа төгсөөд эргээд сумандаа ажиллах хүсэл зориг нэмэгдүүлэх зорилготой /
- Эрүүл мэндийн салбарын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн эрүүл мэндийн салбарын шаардлагатай төнөг төхөөрөмжийг авах тал дээр эрчимжүүлэн дэмжиж ажиллах /сумандаа хүссэн үзлэг оношлогоог хийлгэдэг болох нөхцөл бүрдэн/
 - Ажлын байр шинээр бий болгож ажилгүйдлийн түвшинг бууруулах
 - Сумын ахмадын өргөөнд амралтын өрөөг нэмж шинээр тохижуулана /өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэнэ /
 - Нэг суурин- нэг бүтээгдэхүүн хөдөлгөөн өрнүүлж сум орон нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгох /сумын үйлвэрлэл эрхлэгчдийн хоршоо байгуулж ажлын байрыг өсөн нэмэгдүүлэх/
 - Улсын болон орон нутгийн захиалгаар бараа үйлчилгээ худалдаж авахад жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулах

Шинэ хүч, шинэ үе хөгжил дэвшилттэй сумыг бид бүтээнэ.

БОЛОВСРУУЛСАН: *Ю. Дэлгэрмаа* **Ю.ДЭЛГЭРМАА**

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ Ю.ДЭЛГЭРМАА МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024.07.19


0000000001

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЮРА ОВОГТОЙ
ДЭЛГЭРМАА СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Говьсүмбэр аймгийн сонгогчид оо

2024.07.19

Миний бие Юрагийн Дэлгэрмаа тус аймагт ажиллаж амьдардаг. Жирийн нэгэн ээж, нэгэн айлын эзэгтэй байна. Би энэ аймагтаа ажиллаж амьдраад нэлээдгүй хугацаа өнгөрлөө. Энэ хугацаанд жижиг гэлтгүй аймаг минь нам там гэж талцан иргэнд биш намд үйлчлэх нь олон зүйл дээр харагдаж байна. Иймд би амьдарч байгаа сум орон нутгаа хөгжүүлэхийн төлөө аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд бие даан нэр дэвшихээр шийдвэрлэлээ. Цаашид орон нутгийн бизнес эрхлэгчид аж ахуйн нэгжүүдийг дэмжин ажиллах сумын иргэдийн эрх ашгийг хамгаалах зайлшгүй шаардлага тулгарч байна гэж үзэж байна. Манай аймаг хамгийн залуу аймаг яагаад бусад аймаг шиг шинэчилэн хөгжиж болохгүй гэж бид үүнд гар бие оролцох ёстой тул энэ шийдвэрийг гаргаад байна. Аймгийн соёл боловсрол ажил эрхлэлт хүрээлэн буй орчны аюулгүй байдалд та бидний оролцоо зайлшгүй хэрэгтэй билээ.

Ийм орон нутагт талцан хуваагдахад цаашдын ажил амьдралд сөрөгөөр нөлөөлж бидний эрүүл аюулгүй амьдрах эрх зөрчигдөж, хийгдэх ёстой албан ажлууд удаашралтай байгаа нь нүдэнд ил байна.

Бидний залуучууд үүнийг зүгээр хараад суулгүйгээр эх орон сум орон нутгаа гэсэн сэтгэлтэй хүмүүсийн төлөөлөл болохоор шийдэж бие даан нэр дэвшиж байна. Болохгүй зүйлийн эсрэг зогсож болж байгаа зүйлийг сайшаан дэмжиж орон нутгаа өөдтэй өнгөтэй байлгахын төлөө үнэний дуу хоолой болж шудрага ёсны төлөөлөл болж ажиллана гэдгээ илэрхийлж байна.

Тиймээс иргэн та:

Эрх мэдэл, хөрөнгөтэй хэн нэгний захиалгаар нэр дэвшээгүй

Өөрийн үзэл бодол байр суурьтай

Үнэнч шударга зарчимч нэгнийг дэмжиж өөрт ээлтэй төрийг бүтээхэд гар бие оролцоорой.

Та бүхний итгэл найдварыг алдахгүй ажиллахын тулд дараах зүйлийг зорилт болгон дэвшүүлж байна.

- Аймгийн хэмжээний барилга орон сууцнуудын 2 талд боржигон өв соёл, монгол түүх дурсгал агуулсан гэрэлтүүлэг хийх / аймгийн өнгө үзэмжинд нөлөөлнө/
- Сургуулиудын номын санг шинэчилж хүүхэд бүрт хүртээлтэй болгох мөн хичээлийн бусад цагаар хичээл хийх таатай орчин бүрдүүлэх ширээ сандал шинэчлэх / хүүхдүүд сурч байгаа орчиндоо тухтай орчинд хичээлээ хийх нөхцөл бүрдэнэ/
- Бүтэн өнчин, нэн ядуу, харах хүнгүй хараа хяналт муу өрхийн хүүхдүүдийг байрлуулж хооллох, сургалт явуулж амьдрах асрамжийн төв байгуулах / хүүхдийн эрх зөргчигдөхөөс сэргийлнэ/

0000000002

- Эрүүл мэндийн салбарын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн эрүүл мэндийн салбарын шаардлагатай төнөг төхөөрөмжийг авах тал дээр эрчимжүүлэн дэмжиж ажиллах / хүссэн үзлэг оношлогоог аймагтаа хийлгэдэг болох нөхцөл бүрдэн/
- Ажлын байр шинээр бий болгож ажилгүйдлийн түвшинг бууруулах
- Үр хүүхэдгүй асрах хүнгүй ахмадыг байрлуулж асардаг ахмадын асрамжийн төв байгуулах
- Нэг суурин- нэг бүтээгдэхүүн хөдөлгөөн сум бүрт өрнүүлж сум орон нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгох /сумын үйлвэрлэл эрхлэгчдийн хоршоо байгуулж ажлын байрыг өсөн нэмэгдүүлэх/

Шинэ хүч, шинэ үе хөгжил дэвшилттэй сумыг бид бүтээнэ.

БОЛОВСРУУЛСАН: *Ю.Дэлгэрмаа* **Ю.ДЭЛГЭРМАА**

15/07
0000000000